

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:**

“6.4.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой эрхээ Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шилжүүлж болно.”

**2/32 дугаар зүйлийн 32.5, 32.6 дахь хэсэг:**

“32.5.Ашгийн төлөө бус төрийн өмчит хуулийн этгээд гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газрын шийдвэрээр ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж болно.

32.6.Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан тохиолдолд ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гадаад ажилтан авч ажиллуулах бол ажлын байрны төлбөрийг хөнгөлж болно.”

**2 дугаар зүйл.** Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн “32.5, 32.6, 32.7” дахь хэсгийн дугаарыг “32.7, 32.8, 32.9” гэж өөрчилсүгэй.

ГАРЫН ҮСЭГ